



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Баталсан хууль нь хүн
бүрт тэгш үйлчилдэг
төр л халгийн
тогтвортой оршдог.

Аристотель

www.nli.gov.mn

Цахим сонин

2024.07.31

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН БУЮУ “ХУУЛЬЧДЫН ӨРГӨӨ”-НИЙ ШАВ ТАВИЛАА

Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр өнөөдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн оффисын барилгын буюу “Хуульчдын өргөө”-ний шав тавилаа. Энэ үеэр Б.Энхбаяр сайд хэлэхдээ “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн оффисын барилга барих төсвийг

2024 оны төсөвт суулган, хөрөнгийг нь баталж, өнөөдөр барилгын шав тавьж буйд баяртай байна. Парламентын ардчилал боловсронгуй болон хөгжиж байгаа энэ цаг үед Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үүрэг, ач холболдол улам нэмэгдэж, цар хүрээ нь өргөжих нь лавтай.

Хэлэлцүүлэг, тооцоо судалгаа нь сайн хийгдсэн, шүүлтүүр давсан хуулиуд л парламентын босго давдаг болно. Тэр утгаараа Хууль зүйн үндэсний хүрээлэн, энд ажиллаж буй эрдэмтэн, судлаачдын үүрэг, оролцоо цаашид улам бүр нэмэгдэнэ” гэсэн юм.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн шинэ барилга нь Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд байрлах бөгөөд 5 давхар, оффисын зориулалттай,

орчин үеийн зураг төслийн шийдлүүдийг шингээсэн, нарны гэрлийн тусгал сайтай, зоорийн давхартай, ногоон байгууламжтай, судлаач, эрдэмтэд тав

тухтай орчинд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх юм. Тус оффисын барилгын ажлыг 2024 онд багтаан ашиглалтад оруулахаар

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛЫН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ” ЭХЭЛЛЭЭ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн санаачилгаар Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэйгээр

Монгол Улсад хоёр дахь удаагаа зохион байгуулж буй; Хууль тогтоомжийн судалгааны аргачлалын сургагч багш бэлтгэх сургалт; өнөөдөр эхэллээ.

Сургалт 2024 оны 07 дугаар сарын 22-ноос 07 дугаар сарын 26-ны өдрийг дуустал үргэлжилнэ.



Тус сургалтыг ХБНГУ-ын Доод Саксон мужийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам болон Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга асан, хатагтай Фридерикэ Витте удирдаж байна. Сургалт “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог

хийх”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” зэрэг сэдвийн хүрээнд үргэлжилнэ. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Эрчим хүчний зохицуулах хороо, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургуулийн нийт 31 хууль зүйн салбарын судлаач, багш, мэргэжилтнүүд хамрагдаж байна.



“ӨМНӨД, ХОЙД СОЛОНГОС БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЧИГ ХАНДЛАГА БА ЗОРИЛТ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛЛОО

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Солонгосын эрх зүйн боловсрол төв, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль тогтоомжийн яам, Нэгдэл ба Хойд Солонгосын Хууль Судлалын Нийгэмлэг, Күүкмин Их Сургуулийн Хойд Солонгосын Хууль Зүйн Судалгааны Төв

хамтран “Өмнөд, Хойд Солонгос болон Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээний эрх зүйн чиг хандлага ба зорилт” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний хурлын Нэгдүгээр хэсгийг “БНСУ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний

эрх зүйн чиг хандлага ба зорилт”, Хоёрдугаар хэсгийг “Монгол Улсын Эмнэлгийн тусламж үйлчилгээний эрх зүйн чиг хандлага ба зорилт”, Гуравдугаар хэсгийг “Хойд Солонгосын Эмнэлгийн тусламж үйлчилгээний эрх зүйн чиг хандлага ба зорилт” сэдвийн хүрээнд явуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.



Энэхүү хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль тогтоомжийн яам, Нэгдэл ба Хойд Солонгосын Хууль Судлалын Нийгэмлэг, Күүкмин Их Сургуулийн төлөөллүүд болох судлаачид, оюутнууд, багш нар оролцлоо.

1800-1202

ЦАГИЙН ХУВААРЬ

08:30-17:30

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН
ЛАВЛАХ ДУГААРТ **08:30-17:30** ЦАГИЙН
ХООРОНД ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР
ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй гэж үзвэл төрийн, төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн этгээд, бусад этгээд цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, баг, хорооны Засаг даргад болон хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд мэдээлэх үүрэгтэй.

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Гэр бүлийн
хүчирхийллийн тухай хууль

**Хүүхдийн эрх,
хууль ёсны ашиг
сонирхлыг эцэг,
эх, асран
хамгаалагч,
харгалзан
дэмжигч, гэр
бүлийн бусад
гишүүн
хамгаалах
үүрэгтэй.**

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХҮҮХЭДТЭЙ

- хүнлэг бус, хэрцгий харьцах,
- ялгаварлан гадуурхах,
- сэтгэл санааны дарамт үзүүлэх,
- заналхийлэх,
- хүч хэрэглэх,
- зөдөж шийтгэх,
- тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх,
- үл хайхрах,
- хүүхдийн дэргэд архидан
согтуурах, мансуурах,
- хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль




Хүчирхийллийг мэдээлэх дугаар:

102,107,108ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Гэр бүлийн хүчирхийллийн

тухай хууль

**Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн,
өртсөн байж болзошгүй гэж үзвэл төрийн,
төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн
этгээд, бусад этгээд цагдаагийн байгууллагад,
цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, баг,
хорооны Засаг даргад болон хүүхдэд
яаралтай тусламж үзүүлэх утасны
үйлчилгээнд мэдээлэх үүрэгтэй.**

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Гэр бүлийн хүчирхийллийн

тухай хууль

**Бүх шатны боловсролын байгууллагын багш,
эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан,
хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа
байгууллага, ажилтан нь:**

**Хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл
санааны байдал, айдас, хичээл таслалт,
сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие
махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа
сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох,
хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах
үүрэгтэй.**



АЯЛАЛ ЗУГААЛГААР ЯВАХДАА АНХААРАХ ЗҮЙЛС

Зуны амралт үргэлжлэн явагдаж буй энэ үед та бүхэндээ аялал, зугаалгаар явахдаа анхаарах зүйлсийг хүргэе. Монгол хүн та улс орныхоо үнэт баялаг нь юм шүү, таны амь нас, эрүүл мэнд үнэ цэнэтэй гэдгийг бүү мартаарай.



Аялал, зугаалгаар явахдаа анхаарах зүйлс

- ❁ Хувийн эмийн сантай явах /шаардлагатай эм бэлдмэл, хэрэгслүүд, гэмтэх үед хэрэглэх ариутгал, боолт, хүйтэн жинтэй байх.../;
- ❁ Анхны тусламж хэрхэн үзүүлэх талаар заавар зөвлөмжийн талаар унших тэмдэглэж авах;
- ❁ Автомашин, мотоцикл, моторт завины даацыг хэтрүүлэхгүй байх, бүрэн бүс тээврийн хэрэгслээр аялал, зугаалганд явахгүй байх;
- ❁ Зам тээврийн аюул, ослоос сэргийлэх /хурд хэтрүүлэхгүй байх, суудлын бүсээ зүүх.../;
- ❁ Автомашин дотор хүүхэд орхихгүй байх /автомашин дотор гадаах хэмээс +20 градусаар илүү их халдаг/;
- ❁ Усанд живэхээс сэргийлэх /голын эрэгт амарч зугаалахдаа бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх.../;
- ❁ Уул, хаданд авирах бол зориулалтын хувцас хэрэглэлийг өмсөх.


“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА

“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

“Хууль дээдлэх ёс”
сэтгүүлийн 2024 оны **IV**
улирлын болон англи хэл
дээрх тусгай дугаарт
бүтээл нийтлүүлэхийг
урьж байна.



Бүтээл хүлээн авах хугацаа:

- 1 IV улирлын дугаарт
нийтлэх бүтээл- **XI сарын**
01 хүртэл
- 2 Англи хэл дээрх тусгай
дугаарт нийтлэх бүтээл-
X сарын 31 хүртэл

Хянан магадлалын хураамж:
100,000 төгрөг



Цахим шуудан: lawjournal@legalinstitute.mn



Холбоо барих утас: 99049334



08:30-17:30
ЦАГИЙН ХУВААРЬ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ИРГЭН ТА ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ,
МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ



1800-1202

ДУГААРТ ХОЛБОГДООРОЙ

